



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 240

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга
хэмжээний тухай

“Дорноговь АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2017 он, 2018 оны жилийн эцсийн байдлаар удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэгт заасныг зөрчиж нийт 57,000,000.00 /тавин долоон сая/ төгрөгийн худалдан авалт хийсэн, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5, 20 дугаар зүйлийг зөрчин үндсэн хөрөнгийн элэгдлийг тайлан тэнцэлд буруу тусгасан зэрэг зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дорноговь АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2017 он, 2018 оны эхний хагас жилийн байдлаар удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Дорноговь АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал А.Баттогтоход дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;

2.2. Үндсэн хөрөнгийн элэгдлийг 2013 оноос хойш ашигласан программ хангамжийн дагуу бүртгэж, үлдэгдэл өртөг, хуримтлагдсан элэгдэл, хөрөнгийн тоо төрлийг тайлан тэнцэлд буруу тусгасныг Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулан шийдвэрлүүлж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 хэсэгт заасны дагуу залруулга хийх;

2.3. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.


ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

А.АРИУНБОЛД

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ЭРДЭНЭБАЯР

0000710



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 09 дугаар сарын 09-ний өдрийн
340 дугаар тогтоолын хавсралт

“Дорноговь АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг
арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Дүн /төгрөгөөр/	Зөрчил, дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
2	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33.1, 48.1 дэх заалтад заасныг зөрчиж худалдан авалт хийсэн	Гүйцэтгэх захирал болон холбогдох ажиллагсад	57,000,000.00	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим хэлбэрээр нээлттэй ил тод зарлаж, журмын дагуу зохион байгуулж, тогтоосон хугацаанд тайлан гаргаж байх
2	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5, 20 дугаар зүйлийг зөрчин үндсэн хөрөнгийн элэгдлийг тайлан тэнцэлд буруу тусгасан	Гүйцэтгэх захирал болон холбогдох ажиллагсад		Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулан шийдвэрлүүлж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 хэсэгт заасны дагуу залрууга хийх
Зөрчил, дутагдлын нийт дүн			57,000,000.0	